

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2024 ОНЫ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын сарын 15

Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг

№	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Биелэлт	Хариуцах байгууллага	Гүйцэтгэлийн хувь	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ							
1	1	Төрийн албаны тухай /Шинэчилсэ н найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, мэргэшлийг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх тухай” А/14 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны чиглэлээр 10 арга хэмжээг хэрэгжүүлсэн.	Эрүүл мэндийн төв	95%	-
2	2	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай 2023-05-04	9.1.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 10.1, 10.2-т заасан эрх бүхий этгээд, албан тушаалтан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:	2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 дугаар тушаалыг байгууллагын цахим хуудсанд байршуулан	Эрүүл мэндийн төв	95%	-

			9.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;	эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад албан хуулийн танилцуулах нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос хуулийн танилцуулгын сургалтыг 1 удаа, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд нөлөөллийн ажлыг 1 удаа зохион байгуулсан. Ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.			
	3		9.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;	Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 6 удаа хуралдан иргэн, хуулийн этгээдээс ирсэн өргөдөл, гомдлыг авч хэлэлцсэн байна. Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ёс зүйн зөрчлийн мэдээг байршуулан ажиллаж байна. Төвийн 14 хоног тутам зохион байгуулдаг эмч нарын яриа болон сувилагчийн ярианд дээр тогтмол танилцуулж дахин алдаа дутагдал гаргахгүй байх тал дээр анхаарал хандуулан ажиллаж байна. Иргэн, хуулийн этгээдээс ирсэн өргөдөл, гомдлыг Ёс зүйн дэд хороогоор нээлттэй авч хэлэлцэн 6 албан хаагчдад ирсэн өргөдлийг хүлээн авсан. Хуралдаанаар 1 албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын дотоод журмын хүрээнд сахилгын шийтгэлийг ногдуулж, бусад ирсэн өргөдлийг эвлэрүүлэн зуучлуулах арга хэмжээг авсан.		100%	-
	4		9.1.3.урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах;	Ёс зүйн дэд хорооны 2024 оны төлөвлөгөөний дагуу хуулийн танилцуулгын сургалтыг 2 удаа зохион байгуулахаар, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг 2 удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувьтай байна.		98%	-

	5		9.1.4.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах;	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, бусад төрийн албан хаагчдын Ажлын гүйцэтгэл дүгнэх , үр дүнгийн урамшуулал олгох журмыг боловсруулан, ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн хариуцлагыг 15 хүртэлх оноогоор тусган оруулсан. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзан үзэж шийдвэрлэн ажиллаж байна.		100%	-
	7		19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр, үйл ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан Ёс зүйн хороонд хүргүүлэх бөгөөд тайланг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулна.	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/215 дугаар тушаалын хүрээнд эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/215 дугаар тушаалын хүрээнд хагас, бүтэн жилээр тушаалын хугацаанд багтаан хүргүүлэн ажилласан. Эрүүл мэндийн төвийн цахим хуудсанд тухай бүр байршуулсан.		100%	-
3	8	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02	19.1.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх;	Эрүүл мэндийн төв нь 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 201 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтний 161 эмэгтэй буюу 80 хувь, 40 эрэгтэй буюу 20 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах, зохистой харьцааг бүрдүүлэх 80:20 харьцаатай, холбогдох тайлан, мэдээг хүргүүлэн ажиллаж байна.	Эрүүл мэндийн төв	100%	-
3 ХУУЛИЙН ХОЛБОГДОХ 8 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ						97.5%	
ХОЁР. УИХ-ЫН ТОГТООЛ							
4	12	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах	3.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг	Хан-Уул эрүүл мэндийн төвийн "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зүйл 17 заалтын хүрээнд боловсруулан хагас бүтэн жилээр хэрэгжүүлэн ажиллаж байна.	Эрүүл мэндийн төв	100%	-

		тухай 2023-06-30 Дугаар 2016 №59	төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны тайлан, мэдээллийг холбогдох дээд шатны байгууллагад тухай бүр хүргүүлэн, биелэлтийг нь хариуцан ажиллаж байна.			
УИХ-ЫН 1 ТОГТООЛЫН ХОЛБОГДОХ 1 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ					100%		
ДӨРӨВ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ							
5	19	Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай 2018-04-11 Дугаар 2018_38	3. Авлигын хор уршиг, хохирлыг ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж, түгээн дэлгэрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудаас гаргасан санал санаачлагад нэгдэн дотоод групп, веб хуудсан 8 мэдээ, мэдээллийг оруулан ажилласан. Авилгын эсрэг сургалтыг зохион байгуулан албан хаагчдад Авлигын эсрэг тараах материал танилцуулан товч мэдээлэл олгосон. Эрүүл мэндийн төвтэй хамтран ажилладаг төр болон хувийн байгууллагуудын хамтран ажиллах урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээнд Авилгын зүйл, заалтыг нэмэлтээр тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Эрүүл мэндийн төв	95%	-
	20		4. Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жилийн хүрээнд бүх нийтээр авлигыг үл тэвчин, тухай бүр илчилж, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэхийн төлөө нягт хамтарч, нэгнээ дэмжин ажиллахыг ард иргэддээ уриалсугай.	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “МЭДЬЕ, НЭГДЭЕ” аяны хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 10 сарын 16-ны А/66 тоот тушаалаар сарын аяны төлөвлөгөө гарган Хан-Уул эрүүл мэндийн төвийн албан хаагч, үйлчлүүлэгч нарт чиглэсэн доорхи арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа. Үүнд: 1. Иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгаа -5 2. Албан хаагч нарт сургалт-2 3. Веб хуудсан байршуулсан мэдээ мэдээлэл-9 байршуулсан байна.		90%	-

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 1 ЗАРЛИГЫН 2 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ					92.5%		
ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ							
6	22	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;	Эрүүл мэндийн төвийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион 2024 онд үе шаттайгаар зохион байгуулан ажиллаад байна. Байгууллагын гадна болон дотно өрөө тасалгааны хаягыг засварын ажил бүрэн дууссаны дараа хос бичгээр жигдлэх, нэг загварт оруулах ажлыг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төвийн 1 давхарын дэмжих төвийн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хосолсон бичгээр хаягжуулалтыг хийсэн байна. 2024 онд нийт албан хаагчдаас монгол бичгийн хэрэглээний судалгааг авсан бөгөөд нийт албан хаагчдын 34 хувь хэрэглээний анхан шатны мэдлэгтэй гэсэн судалгаа гарсан бөгөөд цаашид сургалтын төлөвлөгөөнд монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтыг хөтөлбөрт тусган ажиллаж байна.	Эрүүл мэндийн төв	90%	-

			5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
7	24	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар: 187	1. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх дараах арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгасугай: 1.1.Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгаж, энэ тухай байгууллагын цахим хуудсанд сар бүр мэдээлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт;	2024 оны байдлаар Засгийн газрын 11-11 төвөөр ирсэн өргөдөл нийт 359 ирсэн байна. Үүнээс төрлөөр нь авч үзвэл: 1. талархал-200 буюу 55,71% 2. гомдол-140 буюу 38,99% 3. хүсэлт-14 буюу 3,89% 4. санал-5 буюу 1,39% Хандалтаар нь авч үзвэл: 1. Өрхийн эрүүл мэндийн төвтэй холбоотой -152 буюу 42,33 % 2. Эрүүл мэндийн төвтэй холбоотой 204 буюу -56,82% 3. Эрт илрүүлэг үзлэг шинжилгээтэй холбоотой 3 буюу 0,83% шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 12 цагтай. хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй. Шийдвэрлэлтийн дундаж хувь 98% гомдлыг бууруулах, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчдийг хүлээн авч, зөв чиглүүлэн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай авах боломжоор хангах үүднээс төвийн даргын 2024 оны 01 сарын 26-ны өдрийн “Ажилтан бүр хөтөч” аян зохион байгуулах тухай А/07 дугаар тушаал гарган 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулж, энэхүү аянд тасаг нэгжийн бүх эмч, ажилчдыг 8 баг болгон үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Мөн “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний хооронд “Оношилгоог сайжруулъя	Эрүүл мэндийн төв	100%	-

				өдөрлөг", 2 сарын аяныг байгууллагын бүх алба, тасгуудын дунд зохион байгуулан ажиллаж байна. Гомдлыг бууруулах, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавьж, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарыг үүрэгжүүлэн ажиллаж байна. гарсан үр дүн: Гомдлын тоо буурч, талархалын тоо өссөн, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 дахин буурсан үзүүлэлттэй байна.			
8	25	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах ТУХАЙ 2022-04-06	1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх" богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дотор судлал, БЗДХ/ХДХВДОХ, андрологи, статистик, зүрх судас, био анагаах, нян судлал, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, эмэгтэйчүүдийн эхо оношлогоо, ургийн эхо оношлогоо, хавдрын хими эмчилгээ, тархины судасны бичлэг, сувилагч, туслах сувилагч зэрэг чиглэлээр нарийн мэргэжлийн, төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх, мэргэжил олгох, урт болон богино хугацааны сургалтад чадавхжуулах сургалтад давхардсан тоогоор 12 эмч тус тус хамрагдсан байна. Эрүүл мэндийн нэгдсэн сан ННЕР системд 2022 холбогдож 5364 хүний мэдээллийг бүртгэж 169566 үзлэг, оношилгоо шинжилгээг хадгалсан байна. Монголын цахилгаан холбооны Call center үйлчилгээг 2022 онд нэвтрүүлж 15 дугаарыг үүлэн технологид /интернет/ шилжүүлснээр дуудлага алдалгүй үйлчилгээ үзүүлж, хяналтын дашбордоор дамжуулж хянах зэрэг давуу талтай болсон.	Эрүүл мэндийн төв	100%	-

			Нэгдсэн цаг захиалгын 18000119, Үндэсний лавлах 19001109, Эрүүл мэндийн төвийн цахим бүртгэл 11341003, Эко киоск төхөөрөмж, E-Mongolia системүүдээс өөрийн сонголтоор цаг товлох үйлчилгээг авах боломжийг нээгээд байна. Цахим үйлчилгээ авсан мэдээлэл: ▪ Цаг товлох үйлчилгээнд 278050 цаг товлогдсон; ▪ Emongolia порталаар 26700 цаг тараагдсан; ▪ Шинжилгээний захиалга 349600 захиалагдсан; ▪ Дүрс оношилгооны бүртгэл 53533 бүртгэгдсэн; ▪ Яаралтай тусламжийн хуудас 4348 нээгдсэн; ▪ 13А цахимаар 13349 олгогдсон; ▪ Эмнэлгийн хуудас 4381 олгогдсон; ▪ Цахим өвчний түүх 4484 нээгдсэн; ▪ Дүрс оношилгооны факс системд 11693 иргэний 1-5 хүртэлх 16670 зургийг дижитал хэлбэрээр хадгалсан; ▪ Шинжилгээний хариу 311004 цахимаар олгогдсон; ▪ Киоск төхөөрөмжөөс 17701 шинжилгээний хариу авсан байна. Улсын гуравдугаар төв эмнэлэг, Улсын нэгдүгээр төв эмнэлгүүдтэй гэрээлэн 2022, 2023 онуудад яаралтай тусламж, хүлээн авах тасгийн эмч нартай телемедицинээр холбогдож зөвлөгөөн хийх анхны холболтыг хийж зөвлөгөөг авч ажилладаг болсон. Цахим хөгжлийн яамтай гэрээлэн ХУР төрийн мэдээлэл, солилцооны системийг 2023 он нэвтрүүлсэн. Эрүүл мэндийн төв нь дижитал эмнэлэг болох зорилтын хүрээнд 12 лабораторийн төхөөрөмж, 13 дүрс оношилгооны төхөөрөмжүүдийг эмнэлгийн нэгдсэн имэйлт			
--	--	--	--	--	--	--

				систем холбон цахимаар иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвшсэн. Жирэмсний хяналтын хөтөч карт, эх хүүхдийн эрүүл мэндийн /ягаан/ дэвтэрийг цахимжуулах ажилд туршилтын эмнэлгээр ажиллаж байна.			
ЗАСГИЙН ГАЗРЫН 3 ТОГТООЛЫН ХОЛБОГДОХ 9 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ					97%		
АРВАН ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ							
9	51	Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-23 Дугаар: А/91	1.Нийслэлийн хэмжээнд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай: 1.1.харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж, шуурхай, хуулийн хугацаанд, үндэслэлтэй хариу өгч, бүрэн барагдуулж шийдвэрлэх; 1.2.өргөдөл, гомдлыг бүртгэж, шилжүүлэх үйл явцын зөрчлийг арилгах, шат дамжлага, шийдвэрлэлтийн хугацааг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг үр дүнтэй хангаж ажиллах; 1.3.саналын шинжтэй өргөдлийг судалж, түүнийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар хуулийн хугацаанд, зохих хэлбэрээр хариуг иргэнд заавал өгч, энэ тухай мэдээллийг өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээнд тусгайлан оруулж хэвших; 1.4.гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхгүй байх;	Гомдлыг бууруулах, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчдийг хүлээн авч, зөв чиглүүлэн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай авах боломжоор хангах үүднээс Төвийн даргын 2024 оны 01 сарын 26-ны өдрийн “Ажилтан бүр хөтөч” аян зохион байгуулах тухай А/07 дугаар тушаал гарган ажиллаж байна. 2024 оны байдлаар байдлаар Засгийн газрын 11-11 төвөөр ирсэн өргөдөл нийт 359 ирсэн байна. Үүнээс төрлөөр нь авч үзвэл: 1. талархал-200 буюу 55,71% 2. гомдол-140 буюу 38,99% 3. хүсэлт-14 буюу 3,89% 4. санал-5 буюу 1,39% Хандалтаар нь авч үзвэл: 1. Өрхийн эрүүл мэндийн төвтэй холбоотой -152 буюу 42,33 % 2. Эрүүл мэндийн төвтэй холбоотой 204 буюу -56,82% 3. Эрт илрүүлэг үзлэг шинжилгээтэй холбоотой 3 буюу 0,83% шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 12 цагтай. хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ, тайланг улирал бүр гарган холбогдох газарт хүргүүлж, байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилладаг. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар Иргэн, хүүлийн	Эрүүл мэндийн төв	100%	-

				этгээдээс ирсэн өргөдөл, гомдлыг Ёс зүйн дэд хороогоор нээлттэй авч хэлэлцэн 6 албан хаагчдад ирсэн өргөдлийг хүлээн авсан. Хуралдаанаар 1 албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын дотоод журмын хүрээнд сахилгын шийтгэлийг ногдуулсан байна.			
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН 1 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ						100%	

ХЯНАСАН:
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛСЭН
ОРЛОГЧ ДАРГА: Х.АЛТАНЧИМЭГ

НЭГТГЭСЭН:
СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, МЭДЭЭЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГА Т.БУЛГАНТАМИР